

ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Их Хурлын 2016 оны 45 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 3.2.29-т “Шинжлэх ухаан, технологи, инновацийн салбарын хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох”-оор, Монгол Улсын Их Хурлын 2017 оны 11 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийн 4-т “Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах”-аар тус тус заасан билээ.

Монгол Улсын Их Хурал 1995 онд Харилцаа холбооны тухай хуулийг анх удаа батлан гаргаж байсан бөгөөд үүний дараа 2001 онд Харилцаа холбооны тухай хуулийн шинэчилсэн найруулгыг батлан мөрдүүлсэн нь өнөөдрийг хүртэл хүчин төгөлдөр үйлчилж байна. Энэ хугацаанд тус хуульд 2003, 2005, 2008, 2010, 2011, 2014, 2015, 2017 онуудад нийт 8 удаа нэмэлт, өөрчлөлт оруулсан байна.

Хуулийг дагаж мөрдсөнөөс хойших 18 жилийн хугацаанд техник, технологид зарчмын шинжтэй томоохон өөрчлөлтүүд гарч, Монгол Улсын нутаг дэвсгэрийг хамарсан тоон дамжуулах сүлжээ, суурин болон үүрэн холбооны сүлжээ, олон сувгийг дамжуулах сансрын хиймэл дагуулын сүлжээг байгуулсан. Эдгээр сүлжээг ашиглан яриа, интернэт, өргөн нэвтрүүлгийн үйлчилгээг хүргэж байна.

Үүний үр дүнд Монгол Улсын эдийн засаг, нийгмийн бүх салбар, иргэдийн амьдралд мэдээлэл, харилцаа холбооны салбарын дэвшилтэт технологи, үйлчилгээ, хэрэглээ нэвтэрч, өдөр тутмын хэрэгцээ, шаардлага, үйл ажиллагааных нь салшгүй хэсэг болсон төдийгүй харилцаа холбоо, мэдээллийн технологи нь тоон эдийн засгийн хөгжлийн гол хөдөлгөгч хүчин зүйл болж байна. Одоогийн хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулийн хүрээнд өнөөгийн харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын харилцааг зохицуулахад дараах бэрхшээл үүсэж байна. Үүнд:

1.Харилцаа холбооны салбарын хурдацтай хөгжил, зах зээл, өрсөлдөөний орчны өөрчлөлт, шинэчлэлтийн чиг хандлагад нийцүүлэн салбарын бодлого, зохицуулалтыг оновчтой болгож, харилцаа холбооны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, Харилцаа холбооны зохицуулах хорооны чиг үүргийг тодорхой болгож, зааглах шаардлагатай байна.

2.Захиргааны ерөнхий хуулийг 2016 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөгдөж эхэлсэнтэй холбоотойгоор харилцаа холбооны салбарын хэм хэмжээ тогтоосон актыг батлах, хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих байгууллагуудыг тодорхой болгох шаардлага бий болсон. Тухайлбал, Харилцаа холбооны зохицуулах хорооноос батлан мөрдүүлж байсан 70 гаруй захиргааны актаас хуулиар тусгайлан эрх олгоогүйн улмаас 50 гаруй нь нийтээр дагаж мөрдөх боломжгүй болж тус салбарт техникийн зохицуулалт хийхэд хүндрэл үүсээд байна.

3.Техник, технологийн хурдацтай хөгжил, дэвшил нь эргээд техник, технологи хоорондын нэгдэн нийлэлтийг бий болгож байгаа бөгөөд энэ нь нийгэм, эдийн засгийн салбар, бизнест төдийгүй хэрэглээний түвшинд, цаашлаад өрсөлдөөний зохицуулалтад шинэ чиг хандлагыг бий болгож байна.

4.Салбар бүрд харилцаа холбоо, мэдээллийн технологи, үйлчилгээ нь харилцан уялдаагүй, нэгдсэн бодлогогүй, асар их хэмжээний хөрөнгө оруулалт давхардаж байна.

5.Монгол Улсад мэдээллийн технологи эрчимтэй хөгжиж, аливаа байгууллагын үйл ажиллагааны салшгүй нэг хэсэг, үйлчилгээний чухал хэрэгсэл болж байгаа хэдий ч мэдээллийн технологийн ашиглалт, хэрэглээтэй холбоотой эрх зүйн зохицуулалт бүрдээгүй байна. Нөгөө талаар, мэдээллийн технологийн бүтээгдэхүүн, шийдлийг авч ашиглах нь хөрөнгө оруулалт ихээр шаардахын зэрэгцээ нэвтрүүлсэн технологи, худалдаж авсан систем нь тухайн байгууллагын үйл ажиллагааг бүрэн дэмжин, стратегийн зорилт, чанар, аюулгүй байдлын шаардлагыг хангаж байгаа эсэхэд аливаа байгууллага бүрэн итгэлтэй байх эрэлт хэрэгцээ үүссэн.

Эдгээр эрэлт, хэрэгцээг мэдээллийн технологийн аудитын үйлчилгээгээр хангадаг боловч манай улсад энэ чиглэлийн харилцааны эрх зүйн орчин бүрэлдээгүй байна.

6.“Төрөөс мэдээлэл, харилцаа холбооны хөгжлийн талаар баримтлах бодлого”-ын 2.3.4-т “мэдээлэл, харилцаа холбооны судалгаа-хөгжлийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, шинжлэх ухаан, технологийн парк байгуулах арга хэмжээ авч Монгол Улсад инноваци, судалгаа-хөгжлийн нэгдсэн тогтолцоо бий болгоно” гэж заасан байдаг.

Энэхүү бодлогыг хэрэгжүүлэх үүднээс харилцаа холбооны салбарын эрдэм шинжилгээ, судалгааны үйл ажиллагааг явуулах, судалгааны үр дүнг бодлого, зохицуулалт, шинэ технологи хөгжүүлэх, үйлдвэрлэл, инновацийн үйл ажиллагаатай холбосон хуулийн зохицуулалтын орчин бүрдүүлэх шаардлага бий болсон.

Иймд эдгээр практик шаардлагыг шийдвэрлэх зорилгоор Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсрууллаа.

Хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.2-т заасны дагуу хуульд өөрчлөлт оруулах хэлбэрээр боловсруулсан бөгөөд хуулийн төсөл 7 зүйлтэй.

Хуулийн төсөлд төрийн бодлого, зохицуулалтын чиг үүргийн ялгаа, заагийг илүү тодорхой болгох, салбарын үр ашигтай, шударга өрсөлдөөнийг дэмжих бодлого, зохицуулалтыг хөгжлийн шинэ шатны зорилго, зорилтуудад нийцүүлэн сайжруулах, салбар бүрд мэдээлэл, харилцаа холбооны хэрэглээ өсөн нэмэгдэж байгаа үед төрийн нэгдсэн бодлого, төлөвлөлт, зохицуулалт, уялдааг хангах, цахим

засаг ба үйлчилгээний удирдлага, тогтолцооны хуулийн зохицуулалт, тоон эдийн засгийг хөгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх асуудлыг зохицуулахаар тусгасан болно.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлээр хуульд дараахь нэмэлт оруулахаар тусгасан. Үүнд:

-Хуулийн 3 дугаар зүйл буюу “Хуулийн нэр томъёоны тодорхойлолт” гэсэн зүйлд “баталгаажуулах”, “домэйн нэр”, “зохицуулалт”, “мэдээллийн технологи”, “норматив баримт бичиг”, “харилцан холболт”, “сүлжээнд холбогдох” гэсэн нэр томъёоны тодорхойлолтыг оруулсан.

-Хуулийн 5 дугаар зүйл буюу “Засгийн газрын бүрэн эрх”-д “харилцаа холбоо, мэдээллийн технологид тулгуурласан бүтээгдэхүүн, үйлчилгээг нэвтрүүлэх нэгдсэн бодлого, хөтөлбөрийг батлах, харилцаа холбоо, мэдээллийн технологийн чиглэлээр мэдлэг шингэсэн өндөр технологи, экспортын чиг баримжаатай үндэсний үйлдвэрлэлийг хөгжүүлэх, бодлогын судалгаа шинжилгээний байгууллага байгуулах, түүний дүрэм болон холбогдох зардлыг санхүүжүүлэх журам батлах” бүрэн эрхийг нэмж тусгав.

-Хуулийн “Харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын бүрэн эрх” гэсэн 6 дугаар зүйлд “харилцаа холбооны тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдсон дүрэм, журам, заавар, харилцаа холбооны салбарын хөгжлийн талаар баримтлах чиглэл, төлөвлөгөө батлах, түүнчлэн харилцаа холбоо, мэдээллийн технологийг хөгжүүлэхтэй холбоотой бодлогын баримт бичгийг холбогдох байгууллагатай хамтран боловсруулж, хэрэгжилтэд нь хяналт тавих,” зэрэг бүрэн эрхийг төрийн захиргааны байгууллагын бүрэн эрхэд нэмж тусгасан.

-Хуульд “Харилцаа холбоо, мэдээллийн технологийн талаархи салбар хоорондын үйл ажиллагаа” гэсэн 6¹ дүгээр зүйл, “Харилцаа холбоо, мэдээллийн технологийн аудит” гэсэн 30¹ дүгээр зүйлийг нэмэхээр хуулийн төсөлд тусгалаа.

Монгол Улсад харилцаа холбоо, мэдээллийн технологи нэгдмэл бодлого, төлөвлөлттэй байх бөгөөд харилцаа холбоо, мэдээллийн технологид тулгуурласан бүтээгдэхүүн, үйлчилгээг нэвтрүүлэх нэгдсэн бодлого, төлөвлөлтийн асуудлыг харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар шийдвэрлэхээр, уул үйл ажиллагааны салбар хоорондын зохицуулалтыг холбогдох захиргааны байгууллага нь харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай хамтран зохион байгуулж байхаар хуулийн төсөлд тусгалаа.

Тухайн байгууллагад ашиглаж байгаа харилцаа холбоо, мэдээллийн технологийн бүтээгдэхүүн, үйлчилгээ, шийдэл, хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр нь стандартын биелэлт, байгууллагын үйл ажиллагааг дэмжих стратегийн зорилтыг хангаж байгаа эсэхийг харилцаа холбооны асуудал эрхэсэн төрийн захиргааны байгууллагаас харилцаа холбоо, мэдээллийн технологийн аудитын эрх авсан

хуулийн этгээд гүйцэтгэх бөгөөд харилцаа холбоо, мэдээллийн технологийн аудит хийлгэх байгууллагын жагсаалтыг Засгийн газар батална.

-Харилцаа холбооны зохицуулах хороо тусгай зөвшөөрөлгүйгээр эрхлэх харилцаа холбооны үйлдвэрлэл, ашиглалт, үйлчилгээг бүртгэхтэй холбогдсон журам, интернэтийн домэйн нэрийн чиглэлээр зохицуулалтын баримт бичиг болон Зохицуулах хорооны ажлын албаны жилийн төлөвлөгөө, төсвийг батлахаар хуулийн төсөлд тусгасан болно.

Хуулийн төслийн **2 дугаар зүйлд** хуулийн 3, 8, 9, 26 дугаар зүйлийн холбогдох заалтад оруулах үг хэллэг, нэр томьёог тусгаж өгсөн.

Хуулийн төслийн **3 дугаар зүйлээр** аж ахуйн нэгж, байгууллага дотоодын хэрэглээний холбооны сүлжээг дотооддоо болон өөрийн салбар, төлөөлөгчийн газар хоорондын үйл ажиллагаанд ашиглах зориулалтаар хот, сум, суурин газарт байгуулж болохоор, дотоодын хэрэглээний холбооны сүлжээг бүртгэх, хязгаарлалт тогтоох, зохицуулах журмыг Зохицуулах хороо батлахаар, “Дотоодын хэрэглээний холбооны сүлжээ” гэсэн 21 дүгээр зүйлийг бүхэлд нь өөрчлөн найруулж, хуулийн зарим хэсгийн заалтыг өөрчлөн найруулахаар тусгасан болно.

Хуулийн төслийн **4 дүгээр зүйлд** хуулийн зарим үг, өгүүлбэр, нэр томьёог өөрчлөхөөр тусгаж, **5 дугаар зүйлээр** хуулийн 8 дугаар зүйлээс “Зохицуулах хорооны жилийн төсвийг Засгийн газар батална.” гэсэн 1 дэх өгүүлбэрийг хасахаар, **6 дугаар зүйлээр** хуулийн 4 дүгээр зүйл, 6 дугаар зүйлийн 6.1.11 дэх заалт, 9 дүгээр зүйлийн 9.1.10 дахь заалтыг тус тус хүчингүй болсонд тооцохоор тусгалаа.

Хууль зүй, дотоод хэргийн яамнаас хийсэн Давхардал, хийдэл, зөрчлийн судалгааны тайланд тулгуурлан зарим нэр томьёо, зохицуулалтыг Монгол Улсын олон улсын гэрээ, жишигт нийцүүлэх, хуулийн зүйл, заалтын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, хуулийн зарим зүйл, хэсэг, заалтыг хэл зүй, найруулгын тухайд ойлгомжтой, тодорхой болгох үүднээс найруулгын шинжтэй зарим өөрчлөлтийг хийсэн болно.

Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхэлж байгаа үйлчилгээ эрхлэгчдийн удирдлага, салбарын эрдэмтэн судлаачид, төрийн болон төрийн бус байгууллагуудын 100 гаруй төлөөллүүдийг оролцуулсан хэлэлцүүлгийг 2018 оны 01 дүгээр сарын 31-ний өдөр Хууль зүйн үндэсний хүрээлэнд, 2018 оны 02 дугаар сарын 23-ны өдөр Харилцаа холбооны салбарын удирдах ажилтны зөвлөгөөнд тус тус танилцуулсан бөгөөд эдгээр хэлэлцүүлэгт оролцогсдоос хуулийн төсөлтэй холбоотой 97 санал ирүүлснийг судлан үзэж төсөлд тусгасны дараа хуулийн төслийн талаар яам, агентлаг, мэргэжлийн байгууллагуудаас санал авахад 17 яам, агентлаг, 3 аж ахуйн нэгж, байгууллага санал ирүүлснийг судлан үзэж хуулийн төсөлд тусгасан.

Мөн түүнчлэн олон нийтээс санал авах зорилгоор Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар, Харилцаа

холбооны зохицуулах хорооны цахим хуудсуудад уг хуулийн төслийг байршуулсан бөгөөд тусгайлсан санал ирээгүй болно.

Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хууль тогтоомжтой нийцсэн бөгөөд хуулийн төсөлтэй холбогдуулан Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг боловсруулсан болно.

-ooOoo-